

2025.08

VIP 76+

126
ГИШҮҮНТЭЙ
АНХНЫ
ПАРЛАМЕНТЫН
1 ЖИЛ



ХҮНЭЭ
ХӨГЖҮҮЛСЭН УЛСАД
**ХӨГЖИЛ
ИРДЭГ**

Мягмарсүрэн

БАДАМСҮРЭН

Монгол Улсын Их Хурлын гишүүн



Монгол Улсын Их Хурал



Мягмарсүрэн БАДАМСҮРЭН

- Монгол Улсын Их Хурлын гишүүн

Харьяалагдаж буй байнгын хороо

- Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны гишүүн
- Эдийн засгийн байнгын хорооны гишүүн



ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛТЭЙ
ТАНИЛЦАНА УУ

 badamsuren@parliament.mn

 Мягмарсүрэнгийн Бадамсүрэн

САНААЧИЛСАН ХУУЛЬ

- Боловсролын ерөнхий хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай
- УИХ-ын хянан шалгах түр хороог байгуулах тухай
- Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
- Хүүхдийн хөгжлийн тухай анхдагч хууль

АЖЛЫН ХЭСЭГ АХАЛСАН

- Шүгэл үлээх журмын талаар хууийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг
- Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг

ПАРЛАМЕНТЫН БҮЛЭГ

- Монгол-Оросын Парламентын бүлгийн гишүүн
- Монгол-Хятадын Парламентын бүлгийн гишүүн
- Монгол-Европын Парламенттай харилцах бүлгийн гишүүн
- Монгол-Америкийн Парламентын бүлгийн гишүүн
- Монгол-Кувейтийн Парламентын бүлгийн дэд дарга
- Монгол-Азербайжаны Парламентын бүлгийн гишүүн

АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮН

- “Өрхийн, бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих” ажлын хэсэг
- “Иргэний шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг хангах” ажлын хэсэг
- “Боловсролын ерөнхий хуулийн хэрэгжилттэй танилцаж, бүх шатны сургуулийн багшийн хомсдолыг бууруулах, үнэлэмжийг дээшлүүлэх болон төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн менежментийг сайжруулах” ажлын хэсэг
- “Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, санал, дүгнэлт гаргах” ажлын хэсэг
- “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох” ажлын хэсэг
- “Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, эрүүл мэндийн даатгалын тогтолцоог оновчтой болгох” ажлын хэсэг
- “Ашигт малтмалын тухай хууль /Шинэчилсэн найруулга/- ийн төсөл боловсруулах” үүрэг бүхий ажлын хэсэг

Эргэх холбоо хөтөлбөрийн хүрээнд

45 сум, 4 тосгон,



9

багийн

5000


орчим иргэнтэй биечлэн уулзсан



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ 2024-2025



ТОЙРОГТОО ХАМГИЙН ИХ АЖИЛЛАСАН ГИШҮҮН



2024 ОНЫ НАМРЫН ЧУУЛГАНЫ ИРЦ





М.Бадамсүрэн

УИХ-ын гишүүн

ХҮНЭЭ ХӨГЖҮҮЛСЭН УЛСАД ХӨГЖИЛ ИРДЭГ

10 —
ГАЗРЫН ТОС АШИГЛАСНЫ
ТӨЛБӨРИЙН 40 ХУВИЙГ
ОРОН НУТГИЙН ХУРИМТЛАЛЫН
САНД ТЭГШ ХУВААРИЛДАГ БОЛНО

12 —
ХИЧЭЭЛЭЭС ГАДУУРХ ХҮҮХДИЙН
ХӨГЖЛИЙГ ТӨРӨӨС ДЭМЖДЭГ
БОЛНО

13 —
ГАДААД УЛСААС ҮРЖЛИЙН АДУУ
ИМПОРТЛОХЫГ 10 ЖИЛЭЭР
ХОРИГЛОНО

14 —
126 ГИШҮҮНТЭЙ ПАРЛАМЕНТЫН
АНХНЫ ХЯНАН ШАЛГАХ
ТҮР ХОРОО ОЮУТОЛГОЙН
АСУУДЛААР БАЙГУУЛАГДЛАА

16 —
ЦАЦРАГ ИДЭВХТ АШИГТ
МАЛТМАЛЫН ТУСГАЙ
ЗӨВШӨӨРЛИЙГ УИХ-ЫН
ЗӨВШӨӨРӨЛ, ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛООР ОЛГОДОГ БОЛЬЁ!

17 —
“ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ
ҮЙЛДВЭР”-ИЙГ ТӨЛӨВЛӨСӨН
ХУГАЦААНД АШИГЛАЛТАД ОРУУЛАХ
ЧИГЛЭЛИЙГ ЗАСГИЙН ГАЗАРТ ӨГӨВ

18 —
“ӨНДӨРХААН-ЧОЙБАЛСАН”
ЧИГЛЭЛИЙН АВТО ЗАМЫН
АСУУДЛААР ЗАМ, ТЭЭВРИЙН
САЙДАД АСУУЛГА ТАВИЛАА

20 —
ӨРХИЙН БИЧИЛ, ЖИЖИГ, ДУНД
ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ
“ЗАСГИЙН ГАЗАРТ ЧИГЛЭЛ ӨГӨХ
ТУХАЙ” БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ БАТЛАГДЛАА

21 —
МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН
ИРЭХ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ
ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭХ АЖЛЫГ
АХАЛЛАА

22 —
ДОТООДЫН ГУРИЛ
ҮЙЛДВЭРЛЭГЧИД ҮГСЭН

ХУЙВАЛДАЖ ҮНЭЭ НЭМБЭЛ
ИМПОРТЫН ТАТВАРЫГ ТЭГЛЭХ
НӨХЦӨЛИЙГ ДАХИН ТАВИНА


23 —
ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГ ХЯНАН
ШАЛГАХ АЖЛЫН ХЭСЭГ БАЙГУУЛАВ

24 —
ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУД
АКТУАР ТООЦООЛЛЫН
АШИГЛАЛТЫГ ЭРЧИМЖҮҮЛНЭ

25 —
БУЙР НУУР УСАН ЗАМЫН БООМТТОЙ
БОЛНО

26 —
ХҮҮХДИЙН СУРЧ ХӨГЖИХ
ОРЧНЫГ БҮРДҮҮЛСЭН БҮТЭЭН
БАЙГУУЛАЛТУУД

27 —
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ
ИРГЭДЭЭ ЖИЛ БҮР ЭРГЭНЭ



126 ГИШҮҮНТЭЙ АНХНЫ ПАРЛАМЕНТЫН 1 ЖИЛ

28 _____
ДОРНОД АЙМАГТ ЗАМЫН БҮТЭЭН
БАЙГУУЛАЛТЫН АЖИЛ ӨРНӨЖ
БАЙНА

29 _____
ОРОН НУТГИЙН БОЛОВСОН
ХҮЧНИЙГ ДЭМЖИХ “НУТГИЙН
ИРЭЭДҮЙ” ТӨСӨЛ ҮР ШИМЭЭ ӨГЧ
БАЙНА

33 _____
ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН “ГУРВАН
ТӨГӨЛДӨРШИЛ” БОДЛОГО
ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР АЖЛЫН
ХЭСГҮҮД АЖИЛЛАЖ БАЙНА

34 _____
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛСНААР ХҮН ТӨВТЭЙ
ХУУЛЬ ЗҮЙН БОДЛОГЫН СУУРЬ
ТАВИГДАНА

35 _____
ЦУСАА ХАНДИВЛАХ ҮЙЛ ЯВЦ
ЭРСДЭЛГҮЙ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН
БОЛОВСРОНГУЙ БОЛОВ

36 _____
ИРГЭДЭЭ СОНСДОГ ТӨРИЙГ
БЭХЖҮҮЛЭХ ЭХНИЙ АЛХАМ БҮЮУ
УТААНЫ СОНСГОЛ

37 _____
ЭД, ЭРХТНЭЭ ШИЛЖҮҮЛЭХ ЭМЗЭГ
БӨГӨӨД МАРГААНТАЙ
АСУУДЛУУДАД ЭРХ ЗҮЙН
ЗОХИЦУУЛАЛТ ХИЙХИЙГ
ЗОРИЛОО

38 _____
ЦАХИМ МӨРИЙТЭЙ ТОГЛООМЫГ
ХУУЛЬЧИЛСНААР ТОГЛОХ
ЗАЛУУСЫН ТОО 65% БУУРНА

39 _____
ТӨР ӨӨРӨӨСӨӨ ЭХЭЛЖ БҮСЭЭ
ЧАНГАЛНА

40 _____
ХҮН ТӨВТЭЙ, ИРГЭНИЙ
ОРОЛЦООТОЙ ПАРЛАМЕНТЫГ
ТӨЛӨВШҮҮЛНЭ

41 _____
21 ЖИЛИЙН ГАЦААНААС ГАРЧ

“ГАШУУНСУХАЙТГАНЦМОД” ХИЛ
ХОЛБОЛТЫН ТӨМӨР ЗАМЫН АЖИЛ
УРАГШИЛЛАА

42 _____
МОНГОЛ УЛСЫН ШИНЭ НИЙСЛЭЛ
ХОТЫГ ИРЭЭДҮЙД СЭРГЭЭН
БАЙГУУЛАХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН
БҮРДЛЭЭ

43 _____
ШИНЭ ЗУУНМОД ХОТЫГ “ХҮННҮ”
ХОТ ГЭЖ НЭРЛЭВ





ХҮНЭЭ ХӨГЖҮҮЛСЭН УЛСАД ХӨГЖИЛ ИРДЭГ

М.Бадамсүрэн
УИХ-ын гишүүн

Монгол Улсын түүхэнд анх удаа 126 гишүүнтэй парламент бүрдэж төлөөллийн зарчим илүү батжиж байна. Тойргоосоо сонгогдсон 78-ын гишүүний нэг болж Дорнод аймгийн удирдлагын багт нийт 11 жил ажиллаж туршлагажсан миний бие иргэдийнхээ итгэлийг өвөртлөн УИХ-д сонгогдон ажиллаад даруй хоёр чуулганы нүүрийг үзээд байна.

Энэ хугацаанд хэдэнтээ асуудлын учгийг ул сууриар нь тайлж, бодлогын түвшинд өөрчлөлт авчрахыг чармайн ажиллаж тодорхой үр дүнд хүрлээ. Хүүхдийн хөгжлийг сургуулийн боловсролоос гадуур дэмжих, авьяас ур чадварыг нь эрт нээн илрүүлэх нь хөгжсөн иргэнийг бүтээхэд чухал үүрэгтэй тул хүүхдийн хөгжил ямагт нэгдүгээрт гэсэн үзэл баримтлалтай уялдуулан “Хүн болох багаасаа” төслийг санаачилсан маань 3 дахь жилдээ Дорнод аймагт хэрэгжиж байна.

“ Хүүхдийн боловсролд оруулсан хөрөнгө оруулалтын үр дүнд ядуурал тогтвортой буурч, алсдаа ажил эрхлэлт нэмэгдэнэ



40 гаруй багц сургалтад хамрагдсан хүүхдүүд маань бүсийн, улсын чанартай тэмцээнүүдэд тогтмол тэргүүн, дэд байруудад шалгарч байгаа нь үндэсний хэмжээний сайн туршлагаар нэрлэгдэж, **Хүүхдийн хөгжлийн анхдагч хууль** болон тэлж өнөөдөр боловсруулах шатандаа явж байна.



Гадаад хэл, Авьяас ур чадвар, Спорт гэсэн 3 чиглэлийн цогц хөтөлбөрт давхардсан тоогоор **5500** хүүхдийг хамруулав.



Бид хүүхдээ хөгжүүлэхийн зэрэгцээ өөрсдөө ч мэдлэгтэй, мэдээлэлтэй иргэн байж, нийгэмдээ дуу хоолойгоо хүргэдэг, төрийн үйл хэрэгт оролцдог, бодлого санаачилдаг боломжоор хангагдсан ХҮН төвтэй үзэл санааг дээдэлсэн ардчилсан нийгэмд амьдарч байна.

Байгалийн баялаг бол ард түмний, иргэн бүрийн өмч гэдгийг олон удаа сонссон байх. Газрын тосны нөөц ашигласны төлбөр, болон борлуулалтын орлогоос Засгийн газарт ногдох хувийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлэх харилцааг зохицуулаагүйн улмаас олборлолт хийгдэж буй газар нутаг, иргэдийн амьдралын чанарт сөргөөр нөлөөлөхийн эсрэг зорилтот ажил хийгдэхгүй байгаад газрын тосны инженер хүний хувьд сэтгэл зовниж, энэ чиглэлийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах болсон юм. Ингэхдээ Орон нутгийн хөгжлийн сан, Бүсийн хөгжлийн сан, аймаг, сум орон нутгийн сангуудад тэгш, хүртээмжтэй хуваарилснаар иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах чиглэлд бие даасан, оновчтой зарцуулалт хийх санхүүгийн боломжийг нээж өгөхийн төлөө явж байна.

Хууль батлагдсанаар

Нөөц ашигласны төлбөрийн

Үндэсний баялгийн сангийн
Ирээдүйн өв санд 50 хувийг



Үндэсний баялгийн сангийн
Хөгжлийн санд 5 хувийг



Үндэсний баялгийн сангийн
Хуримтлалын санд 5 хувийг



Орон нутгийн хөгжлийн
нэгдсэн санд 10 хувийг



Тухайн бүсийн хөгжлийн
санд 10 хувийг



Тухайн аймгийн Орон нутгийн
хөгжлийн санд 10 хувийг



Тухайн сумын Орон нутгийн
хөгжлийн санд 10 хувийг
хуваарилах эрх зүйн орчин
бүрдэх юм.



Хөдөлмөр, нийгэм хамгааллын яамны харьяа Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь 300 хүртэлх сая төгрөгийн зээл олгодог. Энэ хуульд тусгаснаар бичил ангиллын зээлийн хэмжээ юм. Хуулийн хэрэгжилтийн явцад үүсдэг асуудлуудыг олж тогтоогоод өөрчлөлт хийх бүрэн эрхийнхээ хүрээнд одоогийн ЖДҮ-г дэмжих санг Бичил бизнесийг дэмжих сан болгон өөрчлөөд Үндэсний баялгийн сангийн Хөгжлийн сангаас санхүүжилт олгож жинхэнэ **ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХАРААТ БУС КОРПОРАЦИ** байгуулах нь илүү оновчтой гэсэн санаачилгыг энэ чиглэлд бодлого боловсруулах ажлын хэсгийн гишүүний хувьд дэвшүүлээд байна.

Газар доорх баялагтаа эзэн байж, зөв менежментийг хийж чадвал Монгол Улсад хөгжил ойрхон байна. Нийгэмд нүүрлээд буй стрессийн үндсэн шалтгаан нь ердөө хэт төвлөрөл. Төвлөрлийг сааруулах гол шийдэл нь Бүсчилсэн хөгжил. Харин орон нутгийн хөгжил нь иргэн бүр чаддаг зүйлээрээ орлого олдог, бүтээгч, үйлдвэрлэгч байхаас хамаарна. Үүний тулд төрийн зүгээс бичил, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих бодлогыг илүү хүртээмжтэй, оновчтой болгох шаардлага бий.

Ийнхүү Дорнодын хязгаарын ард түмнээ төлөөлөн Монгол Улсын Их Хурлын нэг эд эс болсноор хүүхэд нь хөгжсөн ирээдүйг бүтээх, иргэд нь чаддаг зүйлээрээ орлого олж амьжиргаагаа дээшлүүлэх, хөрсөн доорх байгалийн баялаг, түүний хүртээмж, тэгш хуваарилалтыг хангах, хөгжсөн иргэн хөгжлийн түүчээ болдгийг өөрөөрөө үлгэрлэхийн төлөө ажилласан нэг жил улирч, бодлого шийдлээ хүлээсэн олон ажил хүлээж байна.



Газрын тос ашигласны төлбөрийн 40 хувийг орон нутгийн хуримтлалын санд ТЭГШ хуваарилдаг болно

Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
Өргөн мэдүүлсэн огноо: 2025.07.09



Ашигт малтмал, газрын тосны нөөц ашигласны төлбөрийн 30-аас доошгүй хувийг олборлолтын сөрөг нөлөөлөлд өртөж буй аймаг, сумдын Орон нутгийн хөгжлийн санд хуваарилдаг байх санаачилгыг Дорнод аймгийн Засаг даргаар ажиллаж байхдаа дэвшүүлсээр ирсэн юм.

Одоогийн хүчин төгөлдөр хэрэгжиж буй Газрын тосны тухай хуулиар нөөц ашигласны төлбөрийн 30 хувийг Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд, 70 хувийг Улсын төсөвт тус төвлөрүүлнэ гэж заасныг өөрчлөн Үндэсний баялгийн санд 60 хувийг, үлдсэн 40 хувийг бүс, орон нутгийн хамаарал бүхий санд төвлөрүүлэхээр өөрчлөн найруулж УИХ-ын даргад өргөн мэдүүлээд байна.


“

Уг хуулийн төслийг Зүүн болон Говийн бүсээс сонгогдсон УИХ-ын 13 гишүүн санал нэгдэн өргөн мэдүүлсэн нь бүс нутгийн төдийгүй бүс хоорондын хамтын ажиллагааны шинэ жишиг болов.

Нөөц ашигласны төлбөрөөс



- Үндэсний баялгийн сангийн Хуримтлалын санд **5** хувийг,
- Үндэсний баялгийн сангийн Хөгжлийн санд **5** хувийг,
- Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд **10** хувийг,
- Тухайн бүсийн хөгжлийн санд **10** хувийг,
- Тухайн аймгийн Орон нутгийн хөгжлийн санд **10** хувийг
- Тухайн сумын Орон нутгийн хөгжлийн санд **10** хувийг хуваарилна



БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

Миний бие УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны гишүүний бүрэн эрхийн хүрээнд 2025 оны нэгдүгээр сарын 15-ны өдөр тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй ашигт малтмал, газрын тосны тусгай зөвшөөрөл эзэмшигчийн улсын төсөвт төлсөн нөөц ашигласны төлбөрийн 30-аас доошгүй хувийг аймаг, сумын орон нутгийн хөгжлийн санд хуваарилах чиглэлээр “Засгийн газарт чиглэл өгөх тухай” байнгын хорооны тогтоол санаачлан батлуулж зорьсон хэргээ нэг алхам урагшлуулаад байсан юм.

Хичээлээс гадуурх хүүхдийн хөгжлийг ТӨРӨӨС дэмждэг болно



“

УИХ-ын гишүүний бүрэн эрхийнхээ дагуу Хичээлээс гадуурх үйл ажиллагаа буюу хүүхэд хөгжүүлэх секц, дугуйлан, сургалтын төвүүд, түүний багш нарт санхүүжилтийн болон байр, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх санал гарган батлууллаа. Хүүхдийн боловсролд оруулсан хөрөнгө оруулалтын үр дүнд ядуурал тогтвортой буурч, алсдаа ажил эрхлэлт нэмэгдэнэ. Үүний ДНБ-д эзэлж байгаа хөрөнгө оруулалтын хувьд хэмжээг эрс нэмэгдүүлэх зоримог алхам хиймээр байна.

Монгол Улс Хүн төвтэй нийгмийг цогцоож “Хүүхэд нэгдүгээрт” зарчмыг баримталдаг болж байна. Өнөөдөр бид хүүхдийн асуудлыг Хүүхэд хамгааллын тухай болон, Хүүхдийн эрхийн тухай хуулиар зохицуулж байна.

Хүүхдээ хамгаалахын сацуу хүүхдээ хөгжүүлэх асуудлыг ЕБС-д даатгаад орхих бус хүүхдийг хувь хүн болгох чиглэлээр олон талыг нь дэмжин хөгжүүлэх төрөл бүрийн хөтөлбөрийг хичээлээс гадуур хэрэгжүүлснээр урлаг, спортын авьяас, ур чадварыг нь эрт нээх, эрт хөгжүүлэх боломжтой. Үүнийг хуульчлан дэмжиж өгснөөр

хүүхдийн хөгжил бодит утгаар биеллээ олно гэж үзэн, НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцид тусгагдсан “Тэгш оролцоотой хүүхэд хөгждөг, хөгжсөн хүүхэд хамгаалагддаг” зарчим болоод УИХ-ын гишүүн М.Бадамсүрэнгийн Дорнод аймгийн засаг дарга байх үедээ санаачлан өдгөө хэрэгжиж буй “Хүн болох багаасаа” төслийг сайн туршлагад үндэслэн Хүүхдийн хөгжлийн анхдагч хуулийн төслөө боловсруулжээ. Энэ жилийн Эх үрсийн баярын өдөр уг хуулийн санаачилгаа орон даяар зарлаж хүүхэд багачуудад бэлэг барьсан бөгөөд удахгүй УИХ-д өргөн барина.

“

Хүүхдийн хөгжилд бүх нийтийн оролцоо хамгийн чухал



Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хүүхэд, гэр бүл хөдөлмөр хамгааллын газрын төлөөлөгчид Дорнод аймагт хэрэгжиж буй “Хүн болох багаасаа” төсөлтэй танилцлаа /2025.06.23/

10 Гадаад улсаас үржлийн адуу импортлохыг жилээр хориглолоо

Малын генетик нөөцийн тухай хуулийн биелэлтэд хяналт, шалгалт хийх, Монгол үүлдэр, омгийн адууны удмын санг хамгаалах тухай УИХ-ын тогтоолын төсөл
Батлагдсан огноо: 2025.07.04

Төрийн сүлдэндээ морио залсан цор ганц улс бол Монгол. Зүүн бүсийн гишүүдийнхээ хамтаар санаачлан боловсруулсан Малын генетик нөөцийн тухай хуулийн биелэлтэд хяналт, шалгалт хийх, Монгол үүлдэр, омгийн адууны удмын санг хамгаалах асуудлаарх УИХ-ын тогтоолын төсөл УИХ-аас 58.2 хувийн дэмжлэг авч 2025 оны долдугаар сарын 4-ний өдөр батлагдлаа.

Ингэснээр 2026 оноос эхлэн 10 жилийн хугацаанд үржлийн адуу, түүний үр хөврөлийг импортлохыг хязгаарлаж байгаа юм.



М.БАДАМСҮРЭН
УИХ-ын гишүүн

Эзэн Чингис хаан морин дэлэн дээр дэлхийн талыг эзэлсэн агуу түүхтэй. Аливаа улс үндэстэнд өөрийн бахарал, үнэт зүйл гэж байдаг бол энэ нь бидний хувьд монгол адуу. Ард иргэд, мэргэжлийн байгууллагууд, парламентын гишүүд бүгд нэгдэж энэхүү тогтоолыг 10 жилийн хугацаатай гаргах нь зөв гэж үзсэн. Харин энэ хугацаанд монгол адуугаа бүртгэлжүүлэх, генетик нөөц, удмыг санг хамгаалах ажлаа бүх нийтээрээ харилцан уялдаатай, бүрэн дүүрэн хийж, үр дүн гаргах зорилтыг дэвшүүлж байна.

Монгол Улсын хилээр
сүүлийн 10 жилийн
хугацаанд



5209

үржлийн адуу орж иржээ.

2024 оны эцсийн байдлаар манай улсад **4,7 сая** толгой адуун сүрэг байгаагийн **1,9 сая** нь үржүүлгийн адуу юм.



126 гишүүнтэй парламентын анхны Хянан шалгах түр хороо **Оюутолгойн асуудлаар** байгуулагдлаа

Хуулийн нэр: УИХ-ын Хянан шалгах
Түр хороо байгуулах тухай тогтоолын төсөл
Өргөн барьсан огноо: 2025.06.27



УИХ-ын гишүүн О.Батнайрамдал, Б.Бадамсүрэн нарын нэр бүхий 89 гишүүний өргөн мэдүүлсэн Хянан шалгах түр хороо байгуулах тухай УИХ-ын тогтоолын төслийг чуулганы /2025.07.02/-ны өдөр хэлэлцэж, гишүүдийн 72.9 хувийн саналаар баталсан юм. Тогтоолын төсөлд “Оюутолгой стратегийн ач холбогдол бүхий

бүлэг ордын хил заагт Канад Улсын хөрөнгө оруулалттай “Онтрэ” ХХК-ийн эзэмшилд буй “ШИВЭЭ ТОЛГОЙ” болон “ЖАВХЛАНТ” ашиглалтын тусгай зөвшөөрлүүд хамаарч байна. Уг хоёр тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах газрын хэвлийн баялгийг ашиглахад Монгол Улсын эрх ашгийг хангахтай

холбоотой гэрээг өнөөдрийг хүртэл байгуулаагүй ирсэн байна. Харин шинэ 126 гишүүнтэй парламентын анхны Хянан шалгах түр хороо Оюутолгойн бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах үр өгөөжийг дээшлүүлэх чиглэлээр ийнхүү УИХ-ын тогтоол амжилттай батлагдлаа.

Хянан шалгах түр хороо байгуулах тухай УИХ-ын тогтоолын төсөлд

- Парламентад суудалтай **5** намын намын **89** гишүүн гарын үсэг зурлаа.



- Түр хороо үндсэн 2 чиглэлээр ажлаа 6 сарын дотор явуулна.

Нэг

Оюутолгой стратегийн бүлэг ордын хил заагт албан ёсоор орсон Канадын хөрөнгө оруулалттай “Онтрэ” компанийн эзэмшилд байгаа Шивээ толгой, Жавхлант 2 лиценз дээр Монгол Улсын эрх ашгийг хангуулж шинэ хөрөнгө оруулалтын гэрээ хийх, холбогдох санал дүгнэлт гаргаж хяналт шалгалтыг хийнэ.



Хоёр

Оюутолгой төслийн зээлийн хүү бууруулах дээр ажиллана. Хувь нийлүүлэгчдийн гэрээгээр 7 жил тутам зээлийн хүүгээ дахин авч хэлэлцэх эрхээ бид нар хэрэгжүүлж өнөөдөр 11,1% байгаа зээлийн хүүг олон улсын жишигт хөөж зайлшгүй бууруулах ёстой.



Хянан шалгах түр хорооны ажлын үр дүнд

- Хувь нийлүүлэгчдийн гэрээгээр **7** жил тутам зээлийн хүүгээ дахин авч хэлэлцэх эрхээ хэрэгжүүлнэ.



- Өнөөдөр **11,1%** байгаа зээлийн хүүг бууруулах боломж үүснэ.

- Ноогдол ашгаа **8-10 жил, 12, 13** жилээр наашлуулах цаашлаад бараг **12, 13** жилээр наашлуулах боломж гарна.



Цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг УИХ-ын зөвшөөрөл, Засгийн газрын тогтоолоор олгодог болъё!




Стратегийн ордууд, газрын тос, уран зэргийг ашигт малтмалын эрэх, хайх, ашиглах харилцааг одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Ашигт малтмалын тухай болон Цөмийн энергийн тухай хуулиар зохицуулдаг бөгөөд Тусгай зөвшөөрлийг төрийн захиргааны байгууллага нь олгохоор тусгасан байдаг.


Гэтэл цацраг идэвхт ашигт малтмал нь үндэсний аюулгүй байдал, улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд нөлөөлөх хэмжээний эрдэс баялгийн хуримтлал тул зөвшөөрлийг нь төрийн эрх барих дээд байгууллага буюу Улсын Их Хурлын зөвшөөрснөөр төрийн гүйцэтгэх байгууллага буюу Засгийн газар шийдвэрлэдэг байх нь зөв гэж үзэж Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан гаргасан зарчмын зөрүүтэй саналыг УИХ-д дэвшүүлээ. Ингэснээр нэг хүний гарын үсгээр улс орны аюулгүй байдалтай холбоотой шийдвэр гардаг байдлыг таслан зогсоох боломжтой.



Улсын хэмжээнд 2025 оны байдлаар цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын ашиглалтын 8 тусгай зөвшөөрлийн талбайд 6 аж ахуйн нэгж эзэмшиж үйл ажиллагаа явуулж байна



Монгол орны нутаг дэвсгэрт цацраг идэвхт ашигт малтмалын 13 орд, 100 орчим илрэл, 1000 гаруй эрдэсжсэн цэг бүртгэлтэй байдаг.



2015 онд Монгол Улсын Ерөнхийлөгч цацраг идэвхт бодисыг стратегийн ордтой адилтган Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулж тусгай зөвшөөрлийг хэрэгжүүлэгч агентлагууд биш зөвхөн Засгийн газрын хуралдаанаар олгоно хэмээн 77-р зарлигтаа тусгасан байдаг.

“Газрын тос боловсруулах үйлдвэр”-ийг төлөвлөсөн хугацаанд ашиглалтад оруулах чиглэлийг Засгийн газарт өгөв



Монгол Улс импортлогч бус үйлдвэржсэн орон болох зорилгын хүрээнд Засгийн газрын 2024-2028 оны төлөвлөгөөндөө 14 мега төсөл хэрэгжүүлэхээр болсны нэг нь “Газрын тос боловсруулах үйлдвэр” юм. Газрын тос, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, түүний хангамжийн асуудал өнгөрсөн зууны эхэн үеэс

аливаа улс үндэстний тусгаар тогтнол, эдийн засгийн аюулгүй байдлын баталгаа, хөгжил дэвшилд хүргэх хамгийн чухал нөхцөл болсоор ирсэн тул 2027 онд бүрэн ашиглалтад оруулахаар төлөвлөжээ. Гэсэн ч дэлхийн зах зээл дээр манай орны орлогын гол эх үүсвэр нүүрсний үнэ унаснаас үүдэж эдийн

засгийн хямрал нүүрлэж байгаа энэ цаг үед дээрх 14 мега төслийг эрэмбэлэх шаардлага үүсээд буй. УИХ-ын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооноос уг төслийг төлөвлөсөн хугацаанд нь ашиглалтад оруулахын тулд авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлийг Засгийн газарт өгсөн юм.

Үүнд:


- Төслийн хяналтыг сайжруулах,
- Гүйцэтгэлийг жил бүр УИХ-аар хэлэлцүүлж, дүгнэлт гаргуулах, дотоод, гадаадаас зээл нэмж авалгүйгээр 2028 оны 1 дүгээр улиралд ашиглалтад оруулах,
- Төслийн ажлын төлөвлөгөөг жил бүр баталж, хэрэгжилт үр дүнг УИХ-аар хэлэлцүүлэх
- Биелэлт хангалтгүй тохиолдолд хариуцлага тооцох
- Үйлдвэрт ашиглах түүхий тосыг дотоодын эх үүсвэрээс бүрэн хангахыг тусгав.



ГАЗРЫН ТОСНЫ
ҮЙЛДВЭРЭЭС ДОТООДЫН
ХЭРЭГЛЭЭНИЙХЭЭ **55** ХУВИЙГ
ХАНГАНА

Үйлдвэр Дорноговь **25**
аймагт байрлах бөгөөд ажлын явц
хувьтай үргэлжилж байна.

Нийт төсөвт өртөг **4.175,8**
тэрбум төгрөг бөгөөд БНЗУ-ын
Эксим банк, Хөгжлийн банк, Эрдэнэс
Тавантолгой ХК-аас санхүүжүүлж байна.




“ӨНДӨРХААН-ЧОЙБАЛСАН” чиглэлийн авто замын асуудлаар зам, тээврийн сайдад асуулга тавилаа




Уг ажлыг “Чайна Гео Инженеринг” ХХК, “Хансуун зам” компаниар тус тус гүйцэтгүүлэх гэрээг 2013 онд Зам, тээврийн яам байгуулж, гүйцэтгэлд хяналт тавих үүргийг хүлээсэн байдаг. Гэтэл чанар, стандартын шаардлага хангаагүйн улмаас эвдрэл, гэмтэл үүсэж, осол аваар олноор гарч, иргэд, зорчигчдийн амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулсаар байна. Яамны зүгээс урсгал засвар, арчлалтыг хийх зохицуулалттай ч Улсын комисс байнгын ашиглалтад аваагүй шалтгааны улмаас хөрөнгө зарцуулах боломжгүй гэж үзсэн юм. Замын гүйцэтгэгч хуулийн этгээдүүд болон Зам, тээврийн яамны тухайн үеийн холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах, хохирлыг барагдуулах асуудлыг шийдвэрлүүлэхээр орон нутгийн засаг, захиргаанаас удаа дараа хууль хяналтын байгууллагад хандсаар ирсэн. Мөн яамнаас хөрөнгө нэхэмжилж шүүхэд хандсан байдаг.

Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн авто замын засвар шинэчлэлийг ажлыг байнгын хороогоор хэлэлцүүлэхээр зэхэж байна.

2013 оны гэрээ болон 2025 оны УИХ-ын шийдвэртэй холбоотой ажлуудын үйл явц, шийдвэр, хэрэгжилт, гүйцэтгэл аль шатандаа явж буй талаарх албан ёсны мэдээллүүдийг ирүүлэхийг хүссэн асуулгыг салбарын сайдад тавилаа.



Мөн Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Б.Жавхланд хандаж уг чиглэлийн 27 км урттай хатуу хучилттай автозамыг шинэчлэх зураг, төсөв хийгдэж магадлалаар батлагдсаны дагуу шаардлагдах 38 тэрбум төгрөгийг 2025 оны Улсын төсвийн төсөлд тусган батлуулж өгөхийг хүссэн албан бичгийг 2024 оны наймдугаар сарын 26-ны өдөр хүргүүлэв.



Мэргэжилтнүүдийн дүгнэлтэд үндэслэн

50 км авто замын шинэчлэлийг

Дэлхийн банкны хөрөнгө оруулалтаар,


27 км автозамыг

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхийг УИХ-аас 2024 онд шийдвэрлэв.

Өрхийн бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих “Засгийн газарт чиглэл өгөх тухай” байнгын хорооны тогтоол батлагдлаа



Орон нутагт ажлын байрыг нэмэгдүүлж, өрхийн орлогыг өсгөх арга бол жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих юм. УИХ-ын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооноос гаргасан Өрхийн бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх бодлогын хүрээнд холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах Ажлын хэсгийг ахалж 5 сар ажиллалаа.



ЖДҮ-ийг дэмжих сангаас олгодог хөнгөлөлттэй зээлд хамрагдах **20 ХҮСЭЛТ ТУТМЫГ НЭГД** л зээл олгож байна.

Гэтэл зээл олголтыг хамгийн багадаа **10-20** дахин нэмэгдүүлж байж иргэд хийж чаддаг зүйлээрээ орлого олох боломжтой болно.

Үүний тулд

- Хөнгөлөлттэй зээлийн үүсвэрийг төсвөөс хараат бусаар буюу Үндэсний баялгийн сангаас жил бүр тогтмол нэмэгдүүлж байх
- Хөнгөлөлттэй зээлийг жилд ганц удаа уралдуулж шалгаруулах бус байнга олгох, түүнчлэн шатлан, тасралтгүй олгох
- Хөнгөлөлттэй зээлийг хөрөнгө оруулалтад 10 жилээс доошгүй, эргэлтийн хөрөнгөд 5 жилээс доошгүй хугацаагаар олгох
- Борлуулалтыг бодлогоор дэмжих, ялангуяа уул уурхайн ААН-үүдийг худалдан авалтаа ил тод зарлаж, орон нутгийн ЖДҮ эрхлэгчдийг дэмжихийг хуульчлах
- Газар, дэд бүтэц, түрээс багатай байраар дэмжих гол өөрчлөлтүүд хийгдэх шаардлагатай гэж үзэн Засгийн газарт чиглэл өгөх 8 хэсэг 30 заалттай Байнгын хорооны тогтоол батлуулж, ирэх намар УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэхээр өргөн барина.

Монгол Улсын хөгжлийн ирэх жилийн төлөвлөгөөг хэлэлцүүлэгт бэлтгэх ажлыг ахаллаа

“Хүн төвтэй” хөгжлийн үзэл санаанд нийцсэн “Эдийн засгийн эрх чөлөөг цогцлоох”-ыг зорьж, эдийн засгийн эрх чөлөөний реформ, төсвийн зардлын реформ, төрийн албаны реформ, үндэсний баялгийн сан, төрийн өмчит компанийн засаглалын реформыг хэрэгжүүлэх хүрээнд 18.9 их наяд төгрөгийн санхүүжилт бүхий 330 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөлөө хэмээн Монгол Улсын 2026 оны хөгжлийн төлөвлөгөөг 2025 оны тавдугаар сарын 29-ний өдөр УИХ батлав.

Аливаа хууль эцэслэн батлагдахын өмнө байнгын хороо хийгээд УИХ-аар хэдэнтээ хэлэлцүүлэгт орж, гишүүдийн оновчтой санал, аливаа техникийн болоод, агуулгын алдаа, дутагдлыг засаж залруулан эцсийн хувилбарт бэлтгэх үйл явц бий. Үүнийг УИХ дотроос мэргэжлээрээ цойлж уг хуулийг “шүүсийг нь шахах” баг бүрэлдэхүүн хийж гүйцэтгэдэг энэ жишгээр ирэх жилийн хөгжлийн төлөвлөгөөг хэлэлцүүлэгт бэлтгэх ажлыг ахалж ажиллалаа.



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

Ирэх жилийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлснээр эдийн засгийн өсөлтийг 1 хүнд ногдох ДНБ-ийг

6% хувьд хадгалж,
8.090 ам.долларт хүргэх боломжтой



Дотоодын гурил үйлдвэрлэгчид үгсэн хуйвалдаж үнээ нэмбэл **импортын татварыг тэглэх нөхцөлийг** **дахин тавина**



2023 оны өвөл 2024 оны хаврын зуднаар мал аж ахуйн салбарыг эрсдэлээс хамгаалах, хүндрэлийг даван туулах зорилгоор улаанбуудайн дээд болон 1-р зэргийн гурил, есөн нэр төрлийн мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлтийг гаалийн албан татвараас чөлөөлөөд байсан ч дотоодын үйлдвэрлэл огцом буурч, түүний нийлүүлэлтийн сүлжээнд оролцогч талуудын үйл ажиллагаанд саад учирч буй тул татвар тэглэснийг хүчингүй болгох хуулийн төсөл УИХ-д хоёронтаа орж ирэн энэ сарын 25-ны өдөр батлагдав.

Дотоодын үйлдвэрлэлээ дэмжих нь чухал ч аливаа салбарт тэргүүлэгч цөөн компаниуд монопол зах зээлийг үүсгэж үнэ зохиомлоор хөөргөдөг тал бий тул уг хуулийн төслийг батлахын хажуугаар топ компаниуд үнээ нэмбэл импортын гурилын татварыг дахин тэглэх асуудлыг оруулж ирнэ гэсэн нөхцөл бүхий УИХ-ын тогтоолыг санаачилж батлуулав.

Импортын татвар тэглэснийг хүчингүй болгосноор гурилын **15** хувь, тэжээлийн **5** хувийн татвар сэргэнэ

“

**УИХ-ын гишүүн
М.Бадамсүрэн:**
**Гурилын импортын
татварыг сэргээж,
дотоодын ААН-үүдээ
дэмжих нь зөв ч монопол
зах зээлийг хянах механизм
хэрэгтэй.**

Үндэсний баялгийн санг хянан шалгах АЖЛЫН ХЭСЭГ байгуулав

Цар тахал, геополитикийн хурцадмал байдал даамжирч хүндрэлүүдийг даван туулахад эдийн засгийн гүйцэтгэлийн тогтвортой байдлыг хадгалах нь маш чухал бөгөөд Монголбанк бодлогын манлайлал үзүүлж ажиллах шаардлагатай цаг үе. Үндэсний баялгийн санд улс төрөөс хараат бус, мэргэжлийн хөрөнгө оруулалтын менежмент, засаглал, нээлттэй мэдээлэл, ил тод байдал дутагдаж байгаа нь УИХ-ын чуулганы 2025 оны дөрөвдүгээр сарын 25-ны өдрийн хуралдаанаар болон Монголбанкны 2024 оны санхүүгийн тайланг хэлэлцэх үеэр онцгойлон ажиглагдаж байв. Миний бие Ирээдүйн өв сангийн валют болон Монголбанкны Төрийн сангийн дансан дахь хуримтлал, Хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгийн төвлөрүүлэлт, гүйцэтгэл болон Үндэсний баялгийн сангийн хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцаж, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах санаачилгыг гаргасан нь дэмжигдсэн юм.



Баялгийн сан нь Ирээдүйн өв сан, Хуримтлалын сан, Хөгжлийн сан гэсэн гурван төрөлтэй бөгөөд 2024 оны жилийн эцсээр **497** тэрбум төгрөг хуримтлагдаж, иргэн бүрт **135** мянган төгрөг олгосон. Иргэдэд дансандаа хадгалж орон сууц, боловсрол, эрүүл мэнд гэсэн салбарт бэлэн бусаар зарцуулах сонголт бий болов



О.БАТНАЙРАМДАЛ
УИХ-ын гишүүн

Эдийн засаг өсөж, төсөв тэлж байгаа үед Үндэсний баялагийн сан тэр дундаа Ирээдүйн өв санд АМНАТ-ийн 65 хувийг төвлөрүүлж явах ёстой байсан. Ингэж бид ирээдүйд гарч болох аливаа эрсдэлээс сэргийлсэн хуримтлалтай болох юм. Тухайлбал, 2024-2025 онд нийтдээ 3.0 их наяд төгрөгийн АМНАТ Ирээдүйн өв санд хуримлагдаж болох байсан. Үүнийг бид цаашдаа засах ёстой

Эрүүл мэндийн байгууллагууд **актуар тооцооллын** ашиглалтыг эрчимжүүлнэ



Т.МӨНХСАЙХАН
УИХ-ын гишүүн

Хуулийн хэрэгжилтийн үр дүнд хөнгөлөлттэй эмийн чирэгдэл багасаж, хүртээмж 58.8 хувиар өссөн ч цар тахлын үеэр ЭМДС-аас зарцуулсан зардлыг буцааж төвлөрүүлээгүйгээс үйл ажиллагаа нь доголдоод байгаа тул бодлогын шинэчлэл хэрэгтэй

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтэй танилцаж, тус салбарын тогтолцоог оновчтой болгох талаар санал дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт орж ажиллалаа.

Хэд хэдэн удаагийн уулзалт хэлэлцүүлгийн дүнд дараах шийдлүүдэд анхаарч ажиллахыг холбогдох яамны хүмүүст санал, зөвлөгөө өглөө.

Эрүүл мэндийн байгууллагын бодит нөхцөл байдалд тулгуурлан актуар тооцооллыг эрчимжүүлэх, нэхэмжлэлийн хяналтын үйл явцыг сайжруулах, оновчтой болгож цахим хэлбэрт шилжүүлэх арга хэмжээ авах, иргэд, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагад хүндрэл, чирэгдэлгүй байхаар санхүүжилтийн хяналтын тогтолцоог бий болгох шаардлагатай байна.

Эрүүл мэндийн даатгалын сан
2024 онд
316
тэрбум төгрөгийн өртэй гарсан.



Үүний **178** тэрбум нь улсын эмнэлэгт, **51** тэрбум нь хувийн хэвшилд, мөн эм ханган нийлүүлэгч байгууллагуудад өр үссэнийг 2025 оны төсөвт суулган, энэ оны I улиралд багтаан өр авлагыг барагдуулав.

Буйр нуур усан замын боомттой болно



М.БАДАМСҮРЭН
УИХ-ын гишүүн

Томоохон орд газар, хилийн боомтуудыг түшиглэж тодорхой хот байгуулах хэрэгтэй. Тэнд ажиллагсад гэрээсээ ажилдаа явдаг, гэр бүл нь тэндээ ажиллаж, сурдаг байх ёстой. Орон нутгийн суурьшлуудыг дэмжиж байж Нийслэлд ирэх ачааллыг бууруулна.

“Эргэх холбоо-9” хөтөлбөрийн хүрээнд өнгөрөгч хоёрдугаар сард Зүүн бүсийн гишүүд бидний тойрогтоо ажиллах үеэр Дорнод аймгийн иргэдэд хүргэсэн баяртай мэдээ нь Буйр нуурын усан замын боомт шинээр байгуулах тухай байв.

Дорнод аймаг боловсрол, дэд бүтэц, зам тээвэр, хот байгуулалт, орон сууцжуулалтын хүрээнд улсын төсвийн 776,7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 2025 онд санхүүжих 159,4 тэрбум төгрөгийн дүнтэй 18 багц ажил хийгдэж байгаагийн нэг нь Буйр нуурын усан замын боомт. Өнөөдрийн байдлаар уг төслийг хэрэгжүүлэх судалгаа, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл хийгдэх шатандаа явж байна.



Монгол Улс нийт **37** хилийн боомттой. Шинэ Сэргэлтийн Бодлогын Боомтын сэргэлтийн хүрээнд боомтын хүчин чадал гурав дахин нэмэгдэнэ

Хүүхдийн сурч хөгжих орчныг бүрдүүлсэн бүтээн байгуулалтууд



Баяндун сумын Улзын хошууны ууган сургуулиудын нэг, төр нийгмийн нэрт зүтгэлтэн, эрдэмтэн зохиолч, Монгол Улсын ууган гавьяат багш, доктор профессор Д.Цэвэгмидийн нэрэмжит Баяндун сумын ерөнхий боловсролын сургууль нь нийт 600 орчим сурагчтай. Сурагчдын суралцах орчинг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор улсын төсвийн 4.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар урлаг заал бүхий 320 хүүхдийн хүчин чадалтай Бага сургуулийн барилгыг ашиглалтад орууллаа.



Ш.ЁЛ

Дорнод аймгийн
Засаг дарга

СӨБ-ын орчны стандартад нийцсэн бага насны хүүхдийн эрүүл, аюулгүй байдлыг хангасан цэцэрлэг ашиглалтад орсноор хамран сургах тойргийн 180 хүүхдийг 100 хувь цэцэрлэгт хамруулж чадахаар болж байна. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудаа дэмжих бодлогыг залгамжлан, бүтээн байгуулалтуудыг хийх болно.



Чойбалсан хотын 12-р сургуулийн Бага сургууль шинээр баригдаж байна. Өмнөх жилүүдэд ачаалал ихтэй ихэнх сургуулийн Бага сургуулийн барилгыг тусад нь шинээр барьж, тусдаа Спортын болон Урлагийн заал, Гал тогоотой байхаар төлөвлөн 1, 5, 8-р сургуульд хэрэгжүүлээд байв. Цаашид бүх сургуулийг нэг ээлжээр хичээллэдэг, 2-оос доошгүй спортын, урлагийн заал, танхимтай болгож, гадна спортын талбай, сургуулийн орчныг шинэчилж үдээс хойш сургууль бүр хичээлээс гадуурх хүүхэд хөгжүүлэх төв болох учиртай.



Мөн Хэрлэн сумын 4-р багт Боловсролын салбарт 10 дахь жилдээ үйл ажиллагаа эрхэлж буй "Түшиц" 16-р цэцэрлэгийн 150 хүүхдийн 6 бүлэгтэй, 29 багш, ажиллагсадтай байх шинэ барилга үүдээ нээлээ. Ингэснээр хүүхэд багачуудын хөгжих таатай, хүртээмжтэй орчныг бүрдүүлж, тэгш оролцоог хангаж чадсаны нэг тод жишээ боллоо.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдээ **жил бүр эргэнэ**



Төрийн үйлчилгээ хүрч үйлчилдэггүй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал тэдний төлөөлөл УИХ-д гарснаар хөндөгдөж эхэлсэн гэхэд хилсдэхгүй. УИХ-ын гишүүн М.Ганхүлэг, адил туршлага, ижил мөртнүүдийн төлөөлөл УИХ-ын гишүүн О.Саранчулууны хамтаар Дорнод аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй өнгөрсөн жилийн аравдугаар сард уулзаж тэдэнд чиглэсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтыг танилцуулж, мэдээлэл өглөө.

Дорнод аймагт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөгжүүлэх, нөхөн сэргээх, сэргээн засах үйлчилгээ үзүүлэх, протез, ортопедын туслах хэрэгсэл засварлах үйлдвэр бүхий хөгжлийн төв өнгөрсөн жил байгуулагдаж өдгөө үйл ажиллагаа нь жигдэрсэн. Аймгийн хэмжээнд 3000 иргэн байгаагаас 300 гаруй нь тогтмол үйлчилгээ авч байна.

“Эргэх холбоо” хөтөлбөрийн хүрээндээ Зүүн бүсээс сонгогдсон гишүүд бид жилд нэг удаа эдгээр иргэдтэйгээ уулзаж, үйл ажиллагаа зохион байгуулж байхаар шийдвэрлэлээ.

Зүүн бүсэд 2024 оны
байдлаар
10661
хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ажиллаж, амьдарч байна



Дорнод аймагт замын бүтээн байгуулалтын ажил өрнөж байна



Зүүн бүс нутгийг түүхэн аялал жуулчлалын төрөлжсөн бүс болгон хөгжүүлж, Бурхан халдун, Халхгол, Буйр нуур, Алтан-Овоо, түүхэн дурсгалт газруудыг дэд бүтцээр холбох зорилт дэвшүүлсэн.

Энэхүү бодлого, зорилт Л.Оюун-Эрдэнийн ЗГ-ын хөтөлбөрт батлагдсан бөгөөд Зүүн бүсэд дараах 3 авто замыг ирэх 3 жилийн дотор шинээр барьж байгуулахаар 2025 оны Улсын төсөвт тусгуулсныг Монгол Улсын Ерөнхий сайд УИХ-д өргөн мэдүүлсэн.

Үүнд:

- Хэнтий аймгийн нутаг дахь Норовлин-Дадал чиглэлийн 54,0 км хатуу хучилттай авто зам
- Дорнод аймгийн нутаг дахь Чойбалсан-Буйр-Халхгол чиглэлийн 256,0 км хатуу хучилттай авто зам
- Сүхбаатар аймгийн нутаг дахь Баруун-Урт-Бичигт боомт чиглэлийн 180,0 км хатуу хучилттай авто зам.

40%



Өнөөдрийн байдлаар Дорнод аймгийн Баян-Уул сумын төвөөс Ульхан боомт, Чойбалсан хотоос Хавирга боомт чиглэлийн хатуу хучилттай автозамын ажил 40 хувьтай үргэлжилж байна

“

Автозамууд баригдсанаар зүүн бүс нутагт аялал жуулчлал хөгжих, хүнс, бараа бүтээгдэхүүн, барилгын материалын үнэ өртөг буурах өндөр ач холбогдолтой

Орон нутгийн боловсон хүчнийг дэмжих “НУТГИЙН ИРЭЭДҮЙ” төсөл үр шимээ өгч байна



Миний бие Дорнод аймгийн Засаг даргаар ажиллах ахуйдаа Сумдад дутагдалтай боловсон хүчний нөөцийг бэлтгэх зорилго дор “Нутгийн ирээдүй” төслийг санаачилсан нь өнөөдрийг хүртэл амжилттай хэрэгжиж үр шимээ хүртэж байна.

2019 оноос хойш 164 оюутны сургалтын төлбөрийг “Нутгийн ирээдүй” төслийг хэрэгжүүлэх зардлаас шийдэж өгснөөр одоогийн байдлаар 50 боловсон хүчин бэлтгэгдэж ирээд орон нутагтаа ажиллаж байна. 2024 онд манай аймаг их эмч, эх баригч, шүдний эмч, багш, газар зохион байгуулагч, малын эмч зэрэг 15 шинэ мэргэжилтнээр хүн хүчээ нэмэгдүүлэв.

Мөн уг төслийн хүрээнд төрийн албан хаагчдад зориулсан “Нутгийн ирээдүй” хоёр давхар 8 айлын тохилог орон сууцны барилга ашиглалтад орж эхэлсэн. Энэ санаачилга хүрээгээ тэлж 2025 оноос Зүүн бүсийн аймгуудын 10 сум, сууринд улсын хөрөнгөөр орон сууцны бүтээн байгуулалт хийгдэхээр болов.



“Нутгийн ирээдүй”
төсөл 2025 онд Монгол Улсын
60 гаруй сум, сууринд
хэрэгжинэ

“

Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөрийг 2025-2027 онд үе шаттайгаар улсын хэмжээнд хэрэгжүүлэхээр 90.0 тэрбум төгрөгийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын багцад тусгууллаа.



З.НОМИН-ЭРДЭНЭ

“Гурванзагал” ЭМТ-ийн
Хүний их эмч

“Нутгийн ирээдүй” төсөлд 2019 оны долдугаар сард хамрагдаж 4 жилийн турш сургалтын төлбөрөө даалгасан. Энэ манай гэр бүлд үүсэх санхүүгийн ачааллыг 80 хувь хөнгөлж өгсөн. Шинэ байрандаа мэргэжил нэгт хань, хүүгийн хамт амьдарч байна. Манайх төвийн орон сууцанд байгаа мэт дотроо 00-той, дулаахан тохьтой байдаг. Нүүрс түлээтэй зууралдаад байхгүй, ажлаасаа ирэхэд дулаахан байдаг нь үнэхээр амар, сайхан байгаа. Цаашдаа мэдээж тогтвор суурьшилтай ажиллана.

М.БАДАМСҮРЭН:

ОРОН НУТГИЙН НЭМЭГДЛИЙН 100 ХУВЬ АЖИЛЛАХ ХҮЧИЙГ ТАТАХАД ГОЛ ХӨШҮҮРЭГ НЬ БОЛСОН

2025.06.27, 2025 оны Төсвийн тодотголын хэлэлцүүлгээс, УИХ

“

Орон нутгийн нэмэгдлийг 100 хувь хүртэл өгөх боломжийг нээж өгсөн. Энэ мэт үр дүн гарсан сонголтоосоо ухарч, төсвийн тодотголоор хасвал орон нутагт дахин хүн очихгүй шүү! Зөв зүйтэй явж байгаа бодлогыг үргэлжлүүлээд явах нь Монгол төрийн эрхэм чанар.

М.БАДАМСҮРЭН:

ТӨВЛӨРЛИЙГ СААРУУЛАХЫН ТУЛД ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ, ТҮҮНИЙ БИЕ ДААСАН БАЙДЛЫГ ХАНГАХ ЁСТОЙ

2025.05.16 Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль шинэчилсэн найруулга, УИХ

“

Ардчилсан нийгмийн үнэ цэнэтэй чухал зүйл бол хэвтээ нутгийн өөрөө удирдах түвшний байгууллагыг бэхжүүлэх тогтолцоо. Нэг аймгийнх нь нутаг нэг улсын нутгаас том хэмжээтэй. Нэгдмэл улс хэдий ч төвлөрсөн суурин газруудыг дэмжихийн тулд төсвийн хувьд бие даасан бодлого чухал. Ингэснээр орон нутаг хөгжиж, төвлөрөл саарна

М.БАДАМСҮРЭН:

БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТУНХГИЙН ШИНЖТЭЙ БАЙЖ БОЛОХГҮЙ

2025.04.25 Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, УИХ

“

Бүсчилсэн хөгжлийн бодлогыг боловсруулахдаа бүсүүдийнхээ тус бүрийн онцлогт нь тохируулж зохицуулалт хийх хэрэгтэй. Цаашид хууль тогтоомжууд, Монгол Улсын бодлогод үүнийг онцгойлон анхаарч тусгах нь зүйтэй.

М.БАДАМСҮРЭН:

ГАДНЫ УЛСУУДАЙ ӨРСӨЛДӨХИЙН ӨМНӨ ДОТООД ОРЧНОО БҮРДҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ

2025.04.23, Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хооронд байгуулах худалдааны түр хэлэлцээрийн төслийн хэлэлцүүлгээс, ЭЗБХ

“

Өндөр хүүтэй зээл авчихаар зардлаа нөхөж, ашиг олоход хэцүү. Хөрөнгө мөнгөтэй, хөгжилтэй, зөв бодлоготой орнуудын зээлийн хүү 3 хувь бол манайд 18-20. ОУ-ын зах зээл дээр яаж өрсөлдөх бэ? Эрх зүйн болоод бизнесийн орчныг давхар сайжруулсны дараа өрсөлдөөнийг ярина.

М.БАДАМСҮРЭН: БҮСҮҮДИЙН ЯЛГААТАЙ БАЙДЛЫГ ТООЦОЖ ХУУЛЬ ТОГТООМЖУУДАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ НЬ ЗҮЙТЭЙ

2025.04.25, Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн хэлэлцүүлгээс, УИХ

“Бүсүүд ялгаатай, тусдаа зохицуулалттай явах шаардлагатай байна. Говийн бүс, Зүүн бүсэд уул уурхайн асуудлууд их тулгамддаг. Бүс бүрт асуудал өөр. Тиймээс Бүсчилсэн хөгжлийн хүрээнд хууль тогтоомжууддаа өөрчлөлт оруулж, зарим асуудлуудаа Засгийн газарт эрхийг нь өгөөд бүсчилсэн байдлаар шийдээд явахгүй бол бүгдийг нэг хуулиар зохицуулах боломжгүй. Монгол Улсын түвшинд сайд нар бүсүүдийн ялгаатай байдлыг дэвшүүлж, бодлогын зохицуулалтуудыг оруулж ирэх ёстой юм.

М.БАДАМСҮРЭН: ТӨР ХҮЧ ХҮРЭХГҮЙ АСУУДЛУУДАА ХУВИЙН ХЭВШИЛТЭЙГЭЭ ХАМТАРЧ ШИЙДВЭРЛЭЖ БОЛНО

2025.05.02 Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудлын хэлэлцүүлгээс

“Алслагдсан сум, багийн түвшинд өрхийн эрүүл мэндийн төв шиг барилга байшин, тоног төхөөрөмжид төрөөс хөрөнгө оруулалт хийгээд, менежментийг хувийн хэвшилд даатгаад явах нь эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зөв гаргалгаа болно доо.



М.БАДАМСҮРЭН: ҮНДЭСНИЙ ОЛБОРЛОЛТЫН КОМПАНИ БАЙГУУЛАХ АЖЛЫГ ЗААВАЛ ХИЙХ ХЭРЭГТЭЙ

2025.01.17 Үндэсний газрын тос боловсруулах үйлдвэрийн талаарх хэлэлцүүлгээс, АБГББХ

“Түүхий эд олборлох асуудлаа гаднын компанид даатгачхаад яриа хэлцэл хийсэн гээд сууж байж болохгүй. Газрын тос нь байхгүй бол үйлдвэрийг нь барих хэрэг юун. Экспортолно гэхээсээ илүүтэй бүтээн байгуулахаар ярьж буй Газрын тосны үйлдвэртээ нийлүүлэхээ бодолцож нөөцийн тооцооллыг яаралтай хийж, нарийвчлан тогтоох шаардлагатай.

М.БАДАМСҮРЭН: МОНГОЛБАНК ИНФЛЯЦЫГ БУУРУУЛАХАД БИЕ ДААСАН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОРИГТОЙ ЯВУУЛАХ ХЭРЭГТЭЙ

“Ипотекийн зээл 6%-ийн хүүтэй байдгийн адилаар орон сууц барьдаг жижиг дунд компаниудад зориулж 6%-ийн хүүтэй зээл олговол үнийн өсөлтөөс хязгаарлах, орон сууцыг барих бодлогыг дэмжих гол зохицуулалт болно.



МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРАЛ

126 ГИШҮҮНТЭЙ
АНХНЫ ПАРЛАМЕНТЫН
1 ЖИЛ

2024 оны намар,
2025 оны хаврын
чуулганаар батлагдсан
гол хуулиуд болон
парламентын
онцлох ажил

Хууль эрх зүйн “ГУРВАН ТӨГӨЛДӨРШИЛ” БОДЛОГО ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР АЖЛЫН ХЭСГҮҮД АЖИЛЛАЖ БАЙНА

2024 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуулиар байгуулагдсан 126 гишүүнтэй шинэ парламентын өмнө хууль эрх зүйн орчныг шинэ цагийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн төгөлдөржүүлэх өндөр хариуцлага бий. Тийм учраас шинэ парламент хууль тогтоох үйл ажиллагаандаа баримтлах үндсэн ГУРВАН чиглэлээ тодорхойлсон юм.

1 Хүний эрхийг дээдэлсэн, хүн төвтэй хуулийн үзэл баримтлалд тулгуурласан эрх зүйн тогтолцоог бүрдүүлнэ.

2 Хууль тогтоомжийг тодорхой, ойлгомжтой болгож, хууль хүн бүрд ижил тэгш үйлчилдэг болгох чиглэлд анхаарна.

3 Нийгмийн хурдацтай хөгжлийн шаардлагад нийцүүлэн, эрх зүйн зохицуулалтыг цаг алдалгүй гаргаж ажиллана.

Энэ хүрээнд УИХ-ын даргын захирамжаар 80 орчим ажлын хэсэг байгуулагдан, ажиллаж байна.



М.БАДАМСҮРЭН

УИХ-ын гишүүн

УИХ-ын Даргын 106 тоот захирамжаар байгуулагдсан Шүгэл үлээх журмын талаар хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг АХАЛЖ, дараах ажлын хэсэгт орж ажиллалаа.

- “Боловсролын ерөнхий хуулийн хэрэгжилттэй танилцаж, бүх шатны сургуулийн багшийн хомсдолыг бууруулах, үнэлэмжийг дээшлүүлэх болон төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн менежментийг сайжруулах”
- “Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, санал, дүгнэлт гаргах”
- Иргэний шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг хангах хүрээнд хот дахин төлөвлөлттэй холбоотой хууль, боловсруулах
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох асуудлыг судлан санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох хуулийн төсөл боловсруулах
- Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, эрүүл мэндийн даатгалын тогтолцоог оновчтой болгох”
- Өрхийн, бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх бодлогын хүрээнд холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгүүдэд ажиллаж байна.



Хууль тогтоомжийн тухай хууль

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар хүн төвтэй хууль зүйн бодлогын суурь тавигдана

УИХ-ын чуулганы 2025 оны хаврын чуулганаар хүн төвтэй, цаг үеийн шаардлагад нийцсэн, иж бүрэн зохицуулалттай, ойлгомжтой хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр Ажлын хэсгүүдийн санал дүгнэлт, боловсруулсан хуулийн төслүүдийг хэлэлцэж байна. Тухайлбал, хүн төвтэй хууль зүйн бодлогын суурь Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар тавигдах ёстой. Хууль бүтээх сэтгэлгээг өөрчлөхгүйгээр эрх зүйн хөгжилд хүрэх боломжгүй. Хуулийн төвд хүн орших учиртай. Хууль хэнийг ч үл ялгаж, эрх тэгш хэрэгжиж, хууль дээдлэх ёс бүрэн тогтох ёстой.

“**Өнөөгийн Монгол Улсын нийгмийн харилцааг 1992 оны Үндсэн хуулиар тунхагласан зарчим, үзэл санаа, түүнд нийцүүлэн боловсруулсан хууль тогтоомжоор зохицуулж байна.**



Д.АМАРБАЯСГАЛАН
УИХ-ын дарга

Өнөөдөр хууль ба журмын зохист харьцаа алдагдсаны улмаас хууль биш, харин журам ноёлж байна. Албан тушаалтны үзэмжээр хандах, авлига, хүнд суртал газар авах хөрс болж байгаа журмуудыг үндсээр нь устгаж, хууль дээдлэх зарчмыг бодит утгаар хэрэгжүүлэх цаг ирсэн.



Д.ЦОГТБААТАР
УИХ-ын гишүүн,
ХЗБХ-ны дарга

Хүн төвтэй үзэл баримтлалд тулгуурлан хуулийн төслийн хүний эрхийн нийцлийг тодорхой аргачлалаар үнэлдэг тогтолцоо нэвтэрч, хуулийн төслөөр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах тохиолдолд тавигдах шаардлагыг тодорхой зохицуулна.





ЦУСАА ХАНДИВЛАХ ҮЙЛ ЯВЦ ЭРСДЭЛГҮЙ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН БОЛОВСРОНГУЙ БОЛОВ

Монгол улс Донорын тухай хуулиар цусны болон эд эс эрхтний донорын асуудлыг зохицуулж байв. Олон нийтэд цусаа өгөхийг уриалах боломжтой ч эд, эс эрхтний донор болохыг ухуулах нь хүнд сэдэв тул хоёр тусдаа хуулиар зохицуулах шаардлага үүссэн юм. Мөн хүн ам өсөн нэмэгдэхтэй зэрэгцэн цусны хэрэглээ нэмэгдэж, ялангуяа хөдөө орон нутагт цусны нөөц асар дутагдалтай байгаа нь, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Цусны төв”-ийг сайжруулж, халдварт өвчин тархаахгүйгээр ажиллах нөхцөл бүрдсэн нь эрх зүйн зохицуулалтыг шинэчлэн сайжруулах үндэс болсон юм.

ЦУСНЫ ДОНОРЫН ТУХАЙ ХУУЛЬ БАТЛАГДСАНААР

- Цусны донорын сургалт, сурталчилгаа сайжирч, орон нутагт ахиц дэвшил гарна
- Цусны донорын нийгмийн халамж, урамшуулал сайжирч, тоо нь нэмэгдэх боломжтой
- Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамж бүрэн шийдэгдэнэ

Монгол Улсад 170 мянган цусны донор бий. Тэд 1 удаа цус өгөхөд

500,000

хүний эрүүл мэнд, амь насыг аварч, амьдрал бэлэглэдэг



Ж.ЧИНБҮРЭН

УИХ-ын гишүүн, Эрүүл мэндийн сайд

Эрчүүдэд элбэг тохиолддог, ноцтой эрүүл мэндийн асуудал үүсгэх эрсдэлтэй төмрийн илүүдэл өвчнийг цусны донор болсноор бүрэн шийдвэрлэх боломжтой.



А.АРИУНЗАЯА

УИХ-ын гишүүн

Би өөрөө боломжоороо цусаа өгөхийг хичээдэг. Таны бэлэглэсэн цус 3 хүний амийг аварна гэж хэлдэг бол цагаа тулбал 3 байтугай 30 хүний цус ч багадаа тохиолдол байдаг. Цусны нөөц, донорын тоог нэмэгдүүлэхийн тулд сургалт, сурталчилгаа, урамшууллыг нэмэгдүүлэх зохицуулалтыг хийх нь маш чухал.





ИРГЭДЭЭ СОНСДОГ ТӨРИЙГ БЭХЖҮҮЛЭХ ЭХНИЙ АЛХАМ БУЮУ УТААНЫ СОНСГОЛ

Нийтийн өргөдөл, гомдлын систем petition.parliament.mn-д Батбаатарын Мөнгөнхишиг иргэний үүсгэсэн “Утааны сонсгол хийцгээе! Төсвийн зарцуулалтад хяналт, үнэлгээ хийж сайжруулцгаая” сэдэвт өргөдөлд 71 мянган иргэн гарын үсэг зурж нэгдсэнээр Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39.1-т заасны дагуу Байнгын хүрээний эрхлэх асуудлын хүрээнд хяналт шалгалт явуулах шаардлагыг биелүүлсэн юм.

- **2024.11.27** Утааны сонсгол хийцгээе! өргөдлийг petition.parliament.mn-д нээв
- **2025.01.15** “Агаарын бохирдол-Хүн амын эрүүл мэнд”-ийн асуудлыг хэлэлцэв
- **2025.01.22** “Зуух, түлшний хяналт, стандартын асуудал”-ыг хэлэлцэв.
- **2025.01.29** “Эрх зүйн орчин, санхүү, хариуцлага”-ыг шүүн нягтлав.
- **2025.02.03** Агаарын бохирдлыг бууруулах хүрээнд утааны асуудлаарх бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн үр дүн, шийдэл” сэдвээр ЕРӨНХИЙ ХЯНАЛТЫН СОНСГОЛ зохион байгуулав.
- **2025.04.15** Утааг багасгах шийдэл бүхий 13 заалттай УИХ-ын тогтоолын төслийг УИХ-д танилцуулахаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо шийдвэрлэв.



Б.БАЯРБААТАР
УИХ-ын гишүүн

Ерөнхий хяналтын сонсголоос гарах шийдвэр нь агаарын бохирдлыг бууруулахад үнэтэй хувь нэмэр оруулах шийдлийг ИНБ, иргэдтэйгээ хамтарч гаргах зайлшгүй том зорилго, том сорилт биднийг хүлээж байна.



Ж.ЧИНБҮРЭН
УИХ-ын гишүүн

Нийслэлээс 32 мянган зуух авах тендер зарлаж, гэр хорооллын айлуудад тараахыг зогсоосон нь уг сонсголын том үр дүн, нөлөөллийн ажил боллоо. Мөн хариуцлагыг нэмэгдүүлэх 13 ажлын чиг үүргийг ЗГ-т хүргүүлээ.



ЭД, ЭРХТНЭЭ ШИЛЖҮҮЛЭХ ЭМЗЭГ БӨГӨӨД МАРГААНТАЙ АСУУДЛУУДАД ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ ХИЙХИЙГ ЗОРИЛОО

Эд, эс, үр шилжүүлэн суулгах эмчилгээний төрлүүд маш хурдацтай хөгжиж байна. Анагаах ухааны гайхамшигтай үр дүнгүүд иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, үр хүүхэдтэй болох, амьдруулах зэргээр хүсэл мөрөөдлийг нь биелүүлдэг болжээ. Ийм учраас цаг үеийн шаардлагаар Эрхтэн, эд эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төслийг УИХ-ын гишүүн Ж.Чинбүрэн нарын гишүүд 2025 оны намрын чуулганаар өргөн мэдүүлж хуралдаанаар хэлэлцсэн юм.

Манай улс анх 2006 онд бөөр шилжүүлэн суулгаснаар эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ эхэлсэн.

- 2011 онд элэг
- 2014 онд ясны чөмөг, үүдэл эс
- 2018 онд элэг шилжүүлэн суулгах баг тус тус байгуулагдаж шилжүүлэн суулгах эмчилгээг хийж байна.



ЭРХТЭН, ЭД ЭС ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БАТЛАГДСАНААР

- Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний эрх зүйн орчин улам боловсронгуй болж, эмчилгээний аргууд улам нэмэгдэж, хөгжин дэвших шинэ боломжууд нээгдэнэ.
- Нийгмийн даатгал төлдөг, эс төлдөг эсэхийг үл хамааран тайтгарлын зардал өгөхөөр тусгасан. Амьгүй донорын гэр бүлд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлэн олгох тэтгэмж бол оршуулгын зардлын хэмжээг тооцсон мөнгөн дүн юм.
- Мөн иргэд эх орондоо дэлхийн жишигт нийцсэн чанартай эмчилгээ үйлчилгээг хүртээмжтэй хүртэх, гадаад улс орон руу эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээнд явах зардал, чирэгдэл мэдэгдэхүйц багасах, гадагшаа урсах мөнгөний урсгал буурна.
- Түүнээс гадна эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах удирдлагын тогтолцоо, үйл ажиллагаа шинэ шатанд гарах, эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ үйлчилгээний шаардлагатай багаж хэрэглэл, тоног төхөөрөмж, шинжилгээ судалгаа, сургалтын үйл ажиллагааны санхүүжилтийн шинэ тогтолцоо бий болон хөгжинэ.



Зөвшөөрлийн тухай хууль

ЦАХИМ МӨРИЙТЭЙ ТОГЛООМЫГ ХУУЛЬЧИЛСНААР ТОГЛОХ ЗАЛУУСЫН ТОО 65% БУУРНА

Цахим мөрийтэй тоглоомын хамгийн том хор уршиг нь “донтолт”. Үүнээс үүдэн залуус амьдралаараа бооцоо тавьж, нийгэмд хөл алдаж байна. Амьдралаа алдаж, өр зээлд орсон олон монгол хүн, олон өрх гэрийн зовлон бидний өмнө байгаа нь нууц биш!

Монгол Улсын хувьд цахим болон цахим бус хэлбэрээр хууль бусаар мөрийтэй болон бооцоот тоглоомын үйл ажиллагаа явуулах замаар мөнгө угаах, бусдыг залилах, татвар төлөхөөс зайлсхийх эдийн засгийн гэмт хэрэгт өнөөдрийг хүртэл нарийвчилсан зохицуулалтгүй явж ирсэн. Тэгвэл улсын эдийн засагт үлэмж хэмжээний хохирол учруулж, эдийн засгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж буй үйлдлийг таслан зогсоох зорилгоор Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж УИХ-аар хэлэлцэн баталлаа.

ХУУЛЬ БАТЛАГДСАНААР ГАРАХ ЗЭРЭГ ҮР ДҮН

Энэ чиглэлийн платформууд хориглогдож, зар сурталчилгаа, агентуудын үйл ажиллагаа бүр мөсөн зогсоно;

Цахим мөрийтэй тоглоом тоглох залуусын тоо 65% буурна;

Гадагш хяналтгүй гарч буй 500 сая ам.долларт зохих байгууллагаас хяналт тавих боломж бүрдэнэ;

Хүүхэд, залуучуудын мөрийт болон бооцоот тоглоом тоглож сэтгэл зүйн хувьд донтох, эрүүл мэнд, амь насанд учрах эрсдэлээс сэргийлнэ;

Мөрийтэй тоглоомыг сурталчлах нь хэвийн мэт хэвшсэн ойлголтыг өөрчилж, хүүхэд, залуучуудыг бооцоот тоглоом, мөрийтэй тоглоомд уриалан дуудаж буй хууль бус сурталчил-гаануудыг таслан зогсооно;

ЭДИЙН ЗАСГИЙН ГЭМТ ХЭРГИЙН
ХОХИРОГЧДЫН 50% НЬ
30-39 НАСНЫХАН

ЦАХИМ МӨРИЙТЭЙ ТОГЛООМЫН
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛЖ,
БУСАД АНХНЫ ХЭМЖЭЭНИЙ
ХОХИРОЛ УЧРУУЛВАЛ

2-8 ЖИЛИЙН
ХОРИХ ЯЛТАЙ



Н.УЧРАЛ

УИХ-ын гишүүн, ЗГХЭГ-ын дарга

Бооцоот тоглоомын сайтаар дамжуулан гэмт хэргийн замаар олсон хууль бус хөрөнгийг гуйвуулах, нуун далдлах, оффшор эргэлтэд оруулах зэрэг нөхцөл байдал тогтоогдсон тул 6036 домэйн хаягийн Монгол Улсаас хандах хандалтыг хязгаарлаад байгаа.





Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Ажлын хэсгийн гишүүн



М.БАДАМСҮРЭН

УИХ-ын гишүүн

Орон нутгийн нэмэгдлийг 100 хувь хүртэл өгөх боломжийг нээж өгсөн. Энэ мэт үр дүн гарсан сонголтоосоо ухарч, төсвийн тодотголоор хасвал орон нутагт дахин хүн очихгүй. Зөв зүйтэй явж байгаа бодлогыг үргэлжлүүлээд явах нь Монгол төрийн эрхэм чанар.

ТӨР ӨӨРӨӨСӨӨ ЭХЭЛЖ БҮСЭЭ ЧАНГАЛНА

УИХ-ын чуулганы энэ хаврын чуулганаар 2025 оны төсвийн тодотголыг яаралтай горимоор хэлэлцэж баталлаа. Нүүрсний үнийн огцом уналтаас голлон шалтгаалж төсвийн орлого 3.2 их наяд төгрөгөөр тасалдах бодит нөхцөл байдал үүссэн. Энэ нөхцөл байдал цаашид даамжирч болзошгүй байгаа. Иймд Засгийн газар “төр өөрөө бүсээ чангалах” хувилбарыг сонгож байгаа. Энэ нь төрийн бүтээмж, үр ашгийг сайжруулах томоохон шинэчлэлийн эхлэл болно гэдгийг Ерөнхий сайд Г.Занданшатар онцлон тэмдэглэж байв.

- Төсөвт байгууллагуудын түлш, халаалтын тарифыг нэмэгдүүлэхээр туссан зардлыг 121.9 тэрбум төгрөгөөр,
- Төрийн тусгай байгууллагуудаас бусад төсвийн байгууллагуудын тээвэр, шатахуун, дотоод албан томилолт, хурал зөвлөгөөний зардлыг 28.9 тэрбум төгрөгөөр,
- Төрийн өндөр дээд айлчлал, зочид төлөөлөгч хүлээж авахаас бусад гадаад томилолт, зочид хүлээж авах зардлыг 4.5 тэрбум төгрөгөөр,
- Бүх шатны төсвийн байгууллагын тавилга, эд хогшил худалдан авах, урсгал засвар хийх болон багаж, техникийн зардлыг 104.4 тэрбум төгрөгөөр,
- Төсвөөс төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад олгох татаасыг 76.8 тэрбум төгрөгөөр,
- Байгууллагаас олгох нэг удаагийн болон бусад тэтгэмж, урамшууллыг 30.2 тэрбум төгрөгөөр,
- Бүх шатны төсвийн байгууллагуудын хэрэгжүүлдэг хөтөлбөр, арга хэмжээний зардлыг 617.3 тэрбум төгрөгөөр хэмнэнэ.

Ингэснээр төсвийн зардал **1 их наяд 508.4 тэрбум** төгрөгөөр буурна гэж үзжээ. Төрийн албан хаагчдын орон тоог 9 хувиар цөөлж **261 тэрбум** төгрөгөөр хэмнэхээр тооцсон байна.

Төсвийн энэхүү тодотгол нь төсөв, мөнгөний бодлогын уялдааг сайжруулж, төлбөрийн тэнцэлд учирч болзошгүй сөрөг дарамтыг 400 орчим сая ам.доллароор бууруулж, монгол төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг тогтворжуулах, үнийн өсөлтийг сааруулах, эдийн засгийн тогтвортой байдал, ард иргэдийн амьжиргаа, баялаг бүтээгчдийн хэвийн үйл ажиллагаанд зохих үр нөлөө үзүүлнэ гэж үзжээ.





Улсын Их Хурал 2024-2028 оны стратеги төлөвлөгөө

ХҮН ТӨВТЭЙ, ИРГЭНИЙ ОРОЛЦООТОЙ ПАРЛАМЕНТЫГ ТӨЛӨВШҮҮЛНЭ

76 гишүүнтэй өмнөх парламент 2023 оны тавдугаар сарын 21-ний өдөр Үндсэн хуулинд өөрчлөлт оруулах түүхэн шийдвэр гаргаснаар өнөөдрийн 126 гишүүнтэй анхны парламент “мэндэлж” 2024-2028 оны стратеги төлөвлөгөөгөө шинэчлэн баталлаа.

Монгол Улсын Их Хурлын бодлого, үйл ажиллагааны цөмд хүн байна. Шинээр гарах хууль бүр хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн, олон талт түншлэлийг сайжруулсан, үндэсний язгуур эрх ашгийг цогцлоосон шинжийг агуулах юм. Мөн иргэн хууль санаачлах, хууль боловсруулахад оролцох, саналаа тусгах, биелэлтэд хяналт тавих, зэргээр улс орны бодлогод ард иргэдийн дуу хоолойг тусгадаг болсноор иргэдийн оролцоотой Ардчилсан парламентын мөн чанарыг бататгасан томоохон өөрчлөлт болов.

УЛСЫН ИХ ХУРАЛ 2024-2028 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨГӨӨ

5 намын оролцоотой ажлын хэсэг нийт

5 зорилго, түүнд хүрэх

17 зорилтыг дэвшүүлсэн юм.



Х.БУЛГАНТУЯА

УИХ-ын гишүүн, Ажлын хэсгийн ахлагч

Энэхүү стратеги төлөвлөгөө нь Улсын Их Хурлын гишүүд, УИХ-ын Тамгын газрын төлөвлөгөө биш. Үүний гол зорилго нь Улсын Их Хурлаас хэлэлцэн батлагддаг хууль тогтоомжууд иргэд, олон нийтэд ээлтэй эрх зүйн орчныг бүрдүүлэх, хүний эрхийн зөрчилгүй нийгмийг цогцлоход чиглэж байгаа.



П.САЙНЗОРИГ

УИХ-ын гишүүн

Бид юуны төлөө яваа, ямар үнэт зүйлийг бэхжүүлэх гэж байгаа талаас нь ойлгож, дэмжиж байна. УИХ-ын дэгийн үйл явцыг илүү тодорхой, нээлттэй болгож, Байнгын хороодын эрхлэх асуудлын хуваарилалтыг оновчтой болгосноор цаашдаа парламентын стратеги зөв болно.





Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнанас төмөр замын Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай

ЗАМЫН-ҮҮД, ЭРЭЭНИЙ
БООМТ ТӨМӨР ЗАМААР
ХОЛБОГДСОНООС ХОЙШ

70 орчим жилийн

ДАРАА ӨМНӨД ХӨРШТЭЙГӨӨ
ТӨМӨР ЗАМААР ХОЛБОГДОХ

ХОЁР ДАХЬ

БООМТЫН ҮҮД, ХААЛГА
НЭЭГДЛЭЭ.

21 ЖИЛИЙН ГАЦААНААС ГАРЧ “ГАШУУНСУХАЙТ-ГАНЦМОД” ХИЛ ХОЛБОЛТЫН ТӨМӨР ЗАМЫН АЖИЛ УРАГШИЛЛАА

Улсын Их Хурал мега төслүүд хэрэгжих эрх зүйн үндсийг бүрдүүлэхэд онцгой анхаарч ажиллаж байгаа. Тухайлбал “Гашуунсухайт-Ганцмод” хил холболтын төмөр замын төсөл гацаанаас гарсан. Үр дүнд нь экспортын хүчин чадал нэмэгдэж, экспортын орлого 2 дахин, төмөр замаар нүүрс экспортлох хүчин чадал хэмжээг 3 дахин, зорчигч болон ачаа тээврийн нэвтрэх хүчин чадал 2 дахин нэмэгдэх юм.

2024.12.27

“Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнанас төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталсан юм.

2025.02.14

“Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т хэлэлцээрт гарын үсэг зурж баталгаажууллаа.

2025.03.27

Гашуунсухайт-Ганцмод боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон баталлаа.




М.БАДАМСҮРЭН

УИХ-ын гишүүн

Эдийн засгийн хувьд эргэж үр өгөөжөө өгөх томоохон төслүүд рүү хөрөнгө оруулах нь хамгийн чухал. Төр хувийн хэвшлийг дэд бүтцээр л дэмжинэ. Төмөр замыг дагаж аж үйлдвэрийн цогцолбор, парк, үйлдвэрүүд баригддаг.





Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хууль

МОНГОЛ УЛСЫН ШИНЭ НИЙСЛЭЛ ХОТЫГ ИРЭЭДҮЙД СЭРГЭЭН БАЙГУУЛАХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН БҮРДЛЭЭ

УИХ-ын 2024 оны намрын чуулганаар хэд хэдэн бие даасан хууль батлагдсаны нэг нь “Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хууль”. Хууль батлагдсанаар нүүдэлчдийн түүхэн гал голомт болсон Орхоны хөндийд суурьшсан эртний нийслэлүүдийн туурин дээр Монгол Улсын шинэ нийслэл хотыг ирээдүйд сэргээн байгуулах хууль эрх зүйн орчин бий болсон юм.

2023

УИХ-ын 07 дугаар тогтоолоор Орхоны хөндийд шинэ Хархорум хотыг байгуулахаар шийдвэрлэсэн.

2024

УИХ-ын даргын 12 тоот захирамжаар уг тогтоолын хэрэгжилтийг хангуулах, бүтээн байгуулалтыг дэмжих чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан

2024

Хуулийн төслийг 2024.12.20 нд өргөн мэдүүллээ

2025

Хуулийн төслийг 2025.01.23-нд баталлаа



Б.БАЯРБААТАР
УИХ-ын гишүүн

Шинэ Хархорум хотын хуультай холбоотойгоор газар эзэмшүүлэх, ашиглуулах гэсэн хоёр заалт өнгөрсөн чуулган дээр саналаар унасан. Уг нь газрын хууль дээр шийдэгдээд явах боломжтой зүйл дээр хөрөнгө оруулалт татах, эрх зүйн орчныг нь хуулиараа нээгээд өгчихсөн бол зүгээр байсан юм.



Н.УЧРАЛ
УИХ-ын гишүүн

Хотыг инженерүүд өөрсдөө л төлөвлөж байгуулж, хувийн хэвшлийн дэмжлэгтэйгээр босгодог. Улаанбаатар хотыг хувийн хэвшил босгосон. Хархорин хот дээр энэ алдааг давтахгүйн тулд төр бас оролцох зүйлдээ оролцоно. Ялангуяа газар олголт дээр оролцох учиртай. Шууд эзэмшүүлж ашиглуулахгүй байх ёстой.





Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хууль

ШИНЭ ЗУУНМОД ХОТЫГ “ХҮННУ” ХОТ ГЭЖ НЭРЛЭВ

“Шинэ Зуунмод” дагуул хотыг байгуулснаар Улаанбаатар хотын төвлөрөл тодорхой хувиар буурахаас гадна Богдхаан, Төмөр зам чөлөөт бүс тээвэр логистикийн МУ-ын эдийн засгийн өсөлтийг 10-15% тэлэх боломжтой. Мөн энэ хотод төр захиргааны байгууллагуудын нэгдсэн цогцолбор байрлах бөгөөд олон улсын нисэх буудлыг түшиглэн олон улсын дээд түвшний уулзалт, арга хэмжээ зохион байгуулах цогцолбор байгуулж үйлчилгээний менежмент, аюулгүй байдлыг хангах тогтолцоог бий болгоно хэмээн үзэж байна.



“Шинэ Зуун мод” гэх нэршил нь Төв аймгийн төв Зуун мод хотын дагуул хот эсхүл Зуун мод хотыг шинэчлэн зохион байгуулах төлөвлөлт гэсэн зөрүү ойлголтыг төрүүлнэ!

ХҮННУ ХОТ ДАРААХ БҮСҮҮДТЭЙ БАЙНА

- Эдийн засгийн чөлөөт бүс
- Шинэ Зуунмод хотын төв, засаг захиргааны бүс
- Оюутны хотхон, судалгаа шинжилгээний бүс
- Тээвэр логистикийн бүс
- Худалдаа, бөөний бүс
- Үйлдвэрийн бүс
- ОУ-ын нисэх онгоцны буудал, агаарын каргоны бүс



М.БАДАМСҮРЭН

УИХ-ын гишүүн

Томоохон орд газар, хилийн боомт, эдийн засгийн онцлог газраа түшиглэж тодорхой хот байгуулах хэрэгтэй. Тэнд ажиллагсад гэрээсээ ажилдаа явдаг, гэр бүл нь тэндээ ажиллаж, сурдаг байх ёстой. Орон нутгийн суурьшлуудыг дэмжиж байж Нийслэлд ирэх ачааллыг бууруулна.



МОНГОЛ УЛСЫН
БАЙНГЫН АЖИЛЛАГААТАЙ ПАРЛАМЕНТЫН ТҮҮХЭН ДЭХ
ЕС ДЭХ УЛСЫН ИХ ХУРАЛ

